25-37

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 25 (598)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2009 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны долдугаар сарын 06 № 25 (598) Улаанбаатар хот

## Гарчиг


### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 311. | Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 535 |
| 312. | Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 536 |
| 313. | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 536 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 314. | Монгол Улсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай | Дугаар 41 | 536 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 315. | Баян-Өлгий аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 120 | 536 |
| 316. | Баянхонгор аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 121 | 539 |
| 317. | Булган аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 122 | 540 |
| 318. | Говь-Алтай аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 123 | 540 |
| 319. | Говьсүмбэр аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 124 | 541 |
| 320. | Дархан-Уул аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 125 | 542 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 321. | Журам батлах тухай | Дугаар 70 | 543 |
| 322. | Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 169 | 559 |

### Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 323. | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай | Дугаар 15 | 560 |


## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 04-ний өдөр** — **Улаанбаатар хот**

### ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Даатгалын тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:**

"4.1.12. "холбогдох этгээд" гэж даатгагч болон даатгалын үйл ажиллагаа эрхэлж байсан, тэдэнд хувьцааны хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд болон Компанийн тухай хуулийн 97.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг."

**2/ 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг:**

"25.5. Даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг даатгалын багц дүрэмд зааснаас өөрөөр зарцуулахыг хориглоно."

**3/ 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт:**

"27.1.5. даатгалын компанийн дүрмийн сангийн болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох этгээд болон түүний үүсгэн байгуулсан банкинд байршуулах."

**2 дугаар зүйл.** Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрийг "Даатгалын компанийн дүрмийн сан нь хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг даатгалын ангилал, давхар даатгалын онцлогийг харгалзан Зохицуулах хороо тогтооно." гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн "даатгагч тухайлбал, Ллойдын андеррайтерын холбоонд багтдаг" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 04-ний өдөр — Улаанбаатар хот

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6.1.8 дахь заалт нэмсүгэй:

"6.1.8. даатгалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, түүнд тавих шаардлагыг тогтоох."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2009 оны 6 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр — Улаанбаатар хот

### НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5.1.15 дахь заалт нэмсүгэй:

"5.1.15. Монгол Улсын төрийн далбааны өдөр: 7 дугаар сарын 10."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 05-ны өдөр — Дугаар 41 — Улаанбаатар хот

### Монгол Улсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2008 оны улсын төсвийн гүйцэтгэлийн орлогыг 1,463,943,717.4 /нэг их наяд, дөрвөн зуун жаран гурван тэрбум, есөн зуун дөчин гурван сая, долоон зуун арван долоо аравны дөрвөн мянга/ мянган төгрөгөөр, зарлагыг 1,745,484,297.4 / нэг их наяд, долоон зуун дөчин таван тэрбум, дөрвөн зуун наян дөрвөн сая, хоёр зуун ерэн долоо аравны дөрвөн мянга/ мянган төгрөгөөр тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр — Дугаар 120 — Улаанбаатар хот

### Баян-Өлгий аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Баян-Өлгий аймгийн харьяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Алтанцөгц сум**

1. Хусаян Мантай - 3-р багт малчин

**Алтай сум**

2. Сейсеп Хатира - Малчин

**Бугат сум**

3. Сания Баткей - Улаантолгой багт малчин
4. Насаибай Казила - Улаантолгой багт малчин

**Булган сум**

5. Кексеген Балхия - 4-р баг гэрийн ажилтай

**Баяннуур сум**

6. Солткен Кулаш - Гэрийн ажилтай

**Дэлүүн сум**

7. Ковкей Элеухан - 5-р багт малчин
8. Түсив Кулзира - 3-р багт тэтгэвэрт
9. Захай Мадениет - 3-р багт малчин
10. Тыханбай Майрагул - 10-р багт малчин
11. Төлеген Саулехан - 5-р багт малчин

**Өлгий сум**

12. Башабек Алиман - Гэрийн ажилтай
13. Тапай Кулахан - Гэрийн ажилтай
14. Мардан Кулай - Гэрийн ажилтай
15. Мардан Камшат - Гэрийн ажилтай
16. Сагди Хуай - Гэрийн ажилтай
17. Халых Жаныл - Өндөр настан
18. Абилке Харылгаш - Гэрийн ажилтай
19. Кунсаний Хиба - Өндөр настан
20. Авдикерим Рота - 3-р багт гэрийн ажилтай

**Сагсай сум**

21. Хабас Бирсия - Тэтгэвэрт
22. Хумархан Кунишай - Гэрийн ажилтай
23. Шерикбай Тауых - Гэрийн ажилтай

**Улаанхус сум**

24. Байтиш Кулимхан - 4-р багт тэтгэвэрт

**Толбо сум**

25. Манкей Кулзира - 6-р багт тэтгэвэрт

**Цэнгэл сум**

26. Цэднэй Дашхүү - 6-р багт малчин
27. Дүгдигбай Намжил - Тэтгэвэрт

**"АЛДАРТ ЭХ"-ИЙН ХОЁРДУГААР ОДОНГООР:**

**Алтай сум**

1. Шабах Кулихан - Малчин
2. Шаривхан Галия - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
3. Халел Сайлаухан - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
4. Тотай Зарыхан - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
5. Нурсолтан Лиза - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
6. Шайхи Ханыкей - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
7. Охай Роза - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
8. Мешел Майра - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
9. Хуанган Еркетай - Сумын ИБМ-ийн ажилтан
10. Хойтиын Туйгын - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

**Алтанцөгц сум**

11. Жайсан Алтангул - Гэрийн ажилтай
12. Хамза Баршагул - Хувиараа бизнес эрхэлдэг
13. Айтуган Бахыт - 4-р багт малчин
14. Мугалимхан Майрагул - 1-р багт малчин
15. Сагдолда Рабига - Гэрийн ажилтай
16. Мухаметхан Бахытгул - 1-р багт малчин
17. Акетай Өркен - 4-р багт малчин
18. Батдэлгэр Хорлоо - 4-р багт малчин

**Буянт сум**

19. Жалдав Амаржаргал - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
20. Норзон Бадамсүрэн - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
21. Мэндээ Раншаан - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

**Бугат сум**

22. Назирбай Айна - Хатуу багт малчин
23. Ашмай Алтангул - Ардын аж ахуйч
24. Малгаждар Алтангул - Бага багт малчин
25. Тогтархажы Баршагул - Хатуу багт малчин
26. Ахат Булбул - Буга багт малчин
27. Рахатжаны Кулиза - Гэрийн ажилтай
28. Алакөз Лиза - Улаантолгой багт малчин
29. Авдкарими Саулегул - Буга багт малчин

**Булган сум**

30. Тате Гүлден - 1-р багт малчин
31. Туркистан Торха - 4-р багт малчин
32. Шакетай Хирмиз - 1-р багт малчин
33. Кекенай Хазине - 1-р багт малчин
34. Бөлшаш Хазине - 5-р багт малчин
35. Хүдэрмагнай Хандсүрэн - 6-р багт малчин

**Дэлүүн сум**

36. Ханан Амине - 9-р багт ажилгүй
37. Баяш Айман - 8-р багт малчин
38. Сураган Амангул - 6-р багт малчин
39. Сарт Бария - 8-р багт малчин
40. Шайпан Бибигул - 2-р багт малчин
41. Хапурат Бибигул - 8-р багт малчин
42. Шошах Гүлжан - Сумын ЗДТГ-ын ажилтан
43. Жагсбай Мөрзет - 4-р багт гэрийн ажилтай
44. Сали Мадине - 8-р багт малчин
45. Жупан Санах - 9-р багт бизнес эрхэлдэг
46. Хахар Саулегул - 8-р багт малчин
47. Какиш Улболсын - 9-р багт гэрийн ажилтай

**Өлгий сум**

48. Абила Айнагул - Аймгийн холбооны газарт
49. Шаригат Асия - Гэрийн ажилтай
50. Ахан Алпеш - Ахмадын хороонд зохион байгуулагч
51. Жапах Амангул - Гэрийн ажилтай
52. Заводхан Айбарша - Гэрийн ажилтай
53. Халыхбай Амангул - Нэгдсэн эмнэлэгт
54. Орсоо Алима - Гэрийн ажилтай
55. Райыс Баршагул - Гэрийн ажилтай
56. Жанаш Билаш - Гэрийн ажилтай
57. Жидай Булбул - Шапигер ӨЭ-т их эмч
58. Ахтышхан Бахира - Өндөр настан
59. Нурахмет Бахытгул - Гэрийн ажилтай
60. Жумайхан Бахытбол - Гэрийн ажилтай
61. Чимэд Баасан - Гэрийн ажилтай
62. Хаманай Гүлмайра - Нэгдсэн эмнэлэгт эмч
63. Уакил Галия - 3-р сургуульд багш
64. Алданыш Гүлнар - "Шипагер" ӨЭ-т сувилагч
65. Шайзан Жабен - Гэрийн ажилтай

66. Иманмалик Жамия - Гэрийн ажилтай
67.Дыбыр Жанар - Гэрийн ажилтай
68. Шойнпил Күлзипа - Гэрийн ажилтай
69. Зейнелхан Күлдир - Гэрийн ажилтай
70. Насихат Күлшай - Гэрийн ажилтай
71. Магзам Кекеш - Гэрийн ажилтай
72. Жиляз Күлиза - Гэрийн ажилтай
73. Займолда Маруза - Багш
74. Магзатай Мария - Өндөр настан
75. Темирбек Магрипа - Гэрийн ажилтай
76. Сайд Манат - Гэрийн ажилтай
77. Хуспанхан Манаргүл - Багш
78. Улархан Мейрамгүл - Гэрийн ажилтай
79. Мадет Еркегүл - Гэрийн ажилтай
80. Темирхан Нурбахша - Цэцэрлэгийн багш
81. Тынымхан Нурдауир - Гэрийн ажилтай
82. Темирхан Нурбахша - Цэцэрлэгийн багш
83. Тынымхан Нурдауир - Гэрийн ажилтай
84. Хурма Сержант - "Кешели" каманд
85. Хаматай Серик - Гэрийн ажилтай
86. Ашим Самал - Гэрийн ажилтай
87. Зайт Света - 6-р цэцэрлэгийн эрхлэгч
88. Загпар Тилеухан - МҮСТөвд багш
89. Мадениет Тамара - Гэрийн ажилтай
90. Бакал Шари - Гэрийн ажилтай
91. Молдагали Шарипа - Гэрийн ажилтай
92. Төлеубай Хуандаг - ХАА эрхлэгч
93. Авдолда Ханшай - Гэрийн ажилтай
94. Байжигит Хумархан - Гэрийн ажилтай
95. Рысхан Харашаш - Гэрийн ажилтай
96. Хали Хатира - Өндөр настан
97. Долгор Хазира - Гэрийн ажилтай
98. Тенселбай Сагила - Өрхийн эмнэлэгт сувилагч
99. Ойров Эрдэнэ - Нэгдсэн больницод жолооч
100. Лувсансодов Өнөржаргал - МХГазарт
101. Рашат Өкеш - Холбооны газарт үйлчлэгч
102. Мардан Тонай - Холбооны газарт
103. Өсерхан Рияш - Нэгдсэн эмнэлэгт асрагч
104. Хисабай Анаргүл - Гэрийн ажилтай
105. Хахарман Мария - Өндөр настан
106. Ахкепеш Нугыбай - Өндөр настан

**Сагсай сум**

107. Тохтаубай Айнагүл - Малчин
108. Улагпан Базар - Малчин
109. Шотай Булшай - Малчин
110. Мустафа Зейнел - Малчин
111. Үкибас Инжил - Малчин
112. Айткен Күлдари - Малчин
113. Өтепберген Маржангүл - Малчин
114. Саухай Сабах - Малчин
115. Жанпейс Саулегүл - Малчин
116. Санай Саяжан - Малчин
117. Мунал Хуанар - Малчин
118. Хожа Шынар - Малчин
119. Хумар Самерия - Малчин
120. Ахыби Разия - Малчин
121. Баглаш Цэцэг - Малчин

**Улаанхус сум**

122. Темирхан Айналган - 7-р багт гэрийн ажилтай
123. Буланбай Алтангүл -6-р багт малчин
124. Хопан Ания - 6-р багт гэрийн ажилтай
125. Хаматай Гүлбаршын - 6-р багт малчин
126. Шамсаба Озат - 5-р багт малчин
127. Авзелхан Раушан - 1-р багт малчин
128. Авдиркарим Сандыгаш - 1-р багт малчин

**Цагааннуур сум**

129. Бапаях Ахлима - Гэрийн ажилтай

**Толбо сум**

130. Хадыс Бахытгүл - 1-р багт малчин
131. Маулит Бахытгүл - 6-р багт малчин
132. Тогтархан Берикгүл - 2-р багт малчин
133. Ныгмет Дина - 5-р багт малчин
134. Байтилкарип Жолдай - 1-р багт малчин
135. Хызай Жыргау - 2-р багт малчин
136. Ахат Хуанар - 5-р багт тэтгэвэрт
137. Каусар Серикбол - 3-р багт малчин
138. Расоль Хапия - 6-р багт тэтгэвэрт

**Цэнгэл сум**

139. Шөлен Айгүл - 1-р багт малчин
140. Кадетай Базила - 5-р багт малчин
141. Ханат Булбултай - 2-р багт малчин
142. Дигилдик Бодай - 1-р багт малчин
143. Нургали Гүлбаршын - 8-р багт малчин
144. Сансызбай Гүлнаш - 2-р багт малчин
145. Дондог Долгор - 7-р багт малчин
146. Сагбат Зауреш - 3-р багт малчин
147. Төкей Кауен - 2-р багт малчин
148. Хавдрасол Күлпан - 2-р багт малчин
149. Арин Майгүл - 5-р багт малчин
150. Навихан Манар - 8-р багт малчин
151. Төлеген Жарасхан - 3-р багт малчин
152. Хайрым Нургайша - 5-р багт тэтгэвэрт
153. Ханай Рина - 1-р багт малчин
154. Хайса Садел - 5-р багт тэтгэвэрт
155. Төмөр Саруул - 6-р багт малчин
156. Дауит Танзила - 3-р багт малчин
157. Омаргажы Халамхан - Багш
158. Цэрвэй Шархүү - 6-р багт малчин

**Баяннуур сум**

159. Хуанбай Асемгүл - Гэрийн ажилтай
160. Сайтхан Алмагүл - Ахлах сургуульд бага ангийн багш
161. Хавый Гакку - Гэрийн ажилтай
162. Мардан Гүлжанар - Гэрийн ажилтай
163. Сейлхан Майра - Гэрийн ажилтай
164. Тажабай Сандугаш - Гэрийн ажилтай
165. Рымбай Ханипа - Гэрийн ажилтай
166. Шамей Шолпан - Гэрийн ажилтай
167. Бөршек Өмирзах - Гэрийн ажилтай

**Ногооннуур сум**

168. Ыбырайхан Айнагүл - Хос харагай баг
169. Жумаханг Гүлболат - Ямаат баг
170. Нурсалхан Жайнагүл - Ямаат баг
171. Адибай Маржангүл - Кызыл кайн баг
172. Санай Тилеген - Хос харагай баг
173. Бауыржан Мая - Малчин
174. Дакен Хиза - Хос харагай баг

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 121 | Улаанбаатар хот

**Баянхонгор аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж , өсгөн хүмүүжүүлсэн Баянхонгор аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

### "АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

**Баацагаан сум**

1. А.Энхтуяа - 1-р багийн малчин

**Баянхонгор сум**

2. Р.Гантөмөр - Тэтгэвэрт
3. Д.Доржготов - Тэтгэвэрт
4. Г.Уранчимэг - Малчин

**Өлзийт сум**

5. С.Цэдэндолгор - 4-р багийн малчин

### "АЛДАРТ ЭХ"-ИЙН ХОЁРДУГААР ОДОНГООР:

**Баацагаан сум**

1. П.Ариунцэцэг - 1-р багт малчин
2. Ц.Сийлэгмаа -

**Баянбулаг сум**

3. Ж.Норолхоо - Групптэй

**Баянхонгор сум**

4. Ц.Алтангэрэл - Групптэй
5. И.Алтанцэцэг - Тэтгэвэрт
6. Ц.Ариунаа - Гэрийн ажилтай
7. С.Баасанжав - Тэтгэвэрт
8. Х.Балжинням - Малчин
9. Ц.Батцэнд - Гэрийн ажилтай
10. Д.Батсайхан - Тэтгэвэрт
11. А.Гантулга - Аймгийн музейн тайлбарлагч
12. Б.Долгормаа - Гэрийн ажилтай
13. Ө.Лхам-Осор - Малчин
14. А.Лхам-Янжин - Тэтгэвэрт
15. Н.Мөнгөнцэцэг - Малчин
16. Б.Мөнхжаргал - Гэрийн ажилтай
17. Л.Нарантуяа - Групптэй
18. Т.Нарантуяа - Худалдагч
19. З.Оюунбилэг - Гэрийн ажилтай
20. Б.Оюунгэрэл - Аймгийн БСГ-ын арга зүйч
21. Н.Оюунцэцэг - 3 дугаар сургуульд тогооч
22. Б.Оюунчимэг - Ажилгүй
23. Ж.Оюун - Гэрийн ажилтай
24. Б.Өлзийтогтох - "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-д байцаагч
25. С.Пунсал - Гэрийн ажилтай
26. Ж.Хоролмаа - Үсчин
27. Ж.Сувдаа - Ажилгүй
28. Б.Тунгалаг - Гэрийн ажилтай
29. Г.Тэрбиш - Гэрийн ажилтай
30. Ч.Удвалцэцэг -Гэрийн ажилтай
31. Б.Цэрэнханд - "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-д байцаагч
32. Б.Эрдэнэчимэг - Тэтгэвэрт
33. Ш.Энхсайхан - Гэрийн ажилтай

**Баянлиг сум**

34. Н.Баярцэцэг - 1-р багийн малчин
35. Х.Нямсүрэн - 4-р багийн малчин

**Баян-Овоо сум**

36. Л.Намхай - 4-р багт хувиараа

**Баян-Өндөр сум**

37. Б.Отгонсүрэн - 1-р багт малчин
38. Ж.Хажидмаа - 1-р багт малчин

**Бөмбөгөр сум**

39. П.Ариунжаргал - Сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтан
40. Л.Бужинлхам - 4-р багт малчин
41. Ч.Оюунтогтох - 1-р багт малчин
42. А.Саранцэцэг - 3-р багт малчин
43. Б.Солонго - 1-р багт малчин
44. Л.Эрдэнэтуяа - 1-р багт малчин

**Бууцагаан сум**

45. П.Ариунаа -2-р багт малчин
46. Л.Нансалмаа - 2-р багт малчин

**Гурванбулаг сум**

47. Т.Чанцалдулам - 4-р багт малчин
48. Р.Чулуунбаатар - 5-р багт худалдагч

**Жаргалант сум**

49. О.Баяраа - 3-р багт малчин
50. С.Жавзаннамжил - Гэрийн ажилтай
51. Ц.Оюундалай - 2-р багт малчин

**Жинст сум**

52. Г.Одончимэг - 3-р багт малчин
53. М.Түвшинжаргал - 2-р багт малчин

**Заг сум**

54\. Ц.Наранцэцэг - Баянбулаг багт малчин
50\. С.Одончимэг - Залаа-Овоо багт малчин
51\. Г.Сайхантамир - Баян-Улаан багт малчин
52\. Г.Сувдчимэг - Баян-Улаан багт малчин

**Өлзийт сум**

53\. С.Дэлгэржаргал - 2-р багт малчин
54\. Н.Оюунсүрэн - Малчин
55\. Ц.Оюунчимэг - Малчин
56\. С.Өлзийжаргал - 3-р багт малчин
57\. М.Хоролмаа - Малчин

**Шинэжинст сум**

58\. С.Өлзиймаа - Гэрийн ажилтай

**Эрдэнэцогт сум**

59\. Б.Чимгээ - 4-р багт малчин

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 122** | **Улаанбаатар хот**

**Булган аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Булган аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Бугат сум**
1. Ойдовын Долгорсүрэн - Малчин

**Булган сум**
2. Төмөрбаатарын Эрдэнэчимэг - Гэрийн ажилтай

**Гурванбулаг сум**
3. Лувсан-Ишийн Нэргүй - Малчин

**"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:**

**Баян-Агт сум**
1. Дамбазундуйн Дашмаа - Гэрийн ажилтай
2. Бямбасүрэнгийн Лхагвасүрэн - Гэрийн ажилтай
3. Уранчимэгийн Мөнгөнтуяа - Малчин
4. Бадарчийн Эрдэнэцэцэг - Малчин

**Баяннуур сум**
5. Цэрэндоржийн Нарантуяа - Малчин
6. Цээпилийн Эрдэнэсүрэн - Малчин

**Бугат сум**
7. Чүлтэмийн Ганчимэг - Гэрийн ажилтай
8. Пүрэвдоржийн Гантуяа - Малчин

**Булган сум**
9. Данзанжамцын Алтанцэцэг - Группэд
10. Мягмарын Баасан - Малчин
11. Бямбын Батжаргал - Малчин
12. Бадамын Бямбасүрэн - "Од" цайны газрын тогооч
13. Даваацэрэнгийн Мөнхцэцэг - Малчин
14. Баатархүүгийн Нарантуяа - Малчин
15. Адъяагийн Оюун-Эрдэнэ - Малчин
16. Цэрэндоржийн Цэрмаа - Малчин

**Гурванбулаг сум**
17. Алтангэрэлийн Баасанжав - Малчин

**Могод сум**
18. Жигжидийн Баяржаргал -Гэрийн ажилтай
19. Доржсүрэнгийн Наранчимэг - Гэрийн ажилтай
20. Түдэвийн Отгон - Гэрийн ажилтай

**Орхон сум**
21. Перлайн Баяраа - Гэрийн ажилтай

**Сайхан сум**
22. Лхагважавын Цэрэнчимэд - Малчин
23. Чулууны Цэцэгмаа - Малчин

**Сэлэнгэ сум**
24. Бямбын Одонтунгалаг - Гэрийн ажилтай
25. Зумбангийн Сарантуяа - Малчин

**Тэшиг сум**
26. Шаандарын Тунгалаг - Малчин

**Хангал сум**
27. Гомбын Бямбаа - Гэрийн ажилтай
28. Буянбатын Саранцэцэг - Гэрийн ажилтай

**Хялгант тосгон**
29. Норовын Алтанцэцэг - Малчин
30. Нямсүрэнгийн Нарантуяа - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 123** | **Улаанбаатар хот**

**Говь-Алтай аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Говь-Алтай аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Бугат сум**
1. Халтарын Бямбацогт - 3-р багийн малчин

**Есөнбулаг сум**
2. Нямрагчаагийн Сосорбурам - Гэрийн ажилтай

"АЛДАРТ ЭХ"-ИЙН ХОЁРДУГААР ОДОНГООР:

**Алтай сум**

1. Оросоогийн Гэрэлмаа - Баянхайрхан багийн малчин

**Баян-Уул сум**

2. Доржийн Гэрэлмаа - Баянхайрхан багийн малчин
3. Цэндхүүгийн Мягмарсүрэн - Баянбогд багийн малчин
4. Ойдовын Болормаа - Алтангадас багийн малчин

**Бигэр сум**

5. Сундуйн Соёлмаа - 1-р багийн малчин
6. Жамбалсүрэнгийн Мөнхзул - 5-р багийн малчин
7. Даваасамбуугийн Байгальмаа - 1-р багийн малчин

**Бугат сум**

8. Хамуутын Буянжаргал - 4-р багийн малчин
9. Баатаржавын Янжмаа - 4-р багийн малчин
10. Мядагмаагийн Буянхишиг - 4-р багийн малчин
11. Дагвын Пүрэв -2-р багийн малчин

**Дарив сум**

12. Даваагийн Түмэндашдулам - 3- багийн малчин
13. Чимэддоогийн Баасанжав - 3-р багийн малчин

**Дэлгэр сум**

14. Өрнөхийн Цэцэгмаа - Баянхонгор багийн малчин

**Жаргалан сум**

15. Сахьяагийн Халтар - Завхан гол багийн малчин

**Тайшир сум**

16. Аварзэдийн Бүрэнтогтох - Малчин
17. Чулуунбатын Норовбанзад - Малчин

**Тонхил сум**

18. Маамуугийн Уртнасан - Алтансоёмбо багийн малчин
19. Рэнцэнгийн Хишигмаа - Алтансоёмбо багийн малчин

**Төгрөг сум**

20. Нямаахүүгийн Нарантуяа - 4-р багийн малчин

**Хөхморьт сум**

21. Пүрэвжавын Одгэрэл - 4-р багийн малчин
22. Баасандоржийн Сүнжидмаа - 1-р багийн малчин
23. Осоржамаагийн Гансүх - 2-р багийн малчин
24. Лхасүрэнгийн Мөнхцэцэг - 4-р багийн малчин

**Цогт сум**

25. Намжилын Ариунаа - Төгрөг багийн малчин
26. Паламдоогийн Лхамжав - Гэгээт багийн малчин
27. Цэдэвдоржийн Батмөнх - Сургуулийн тогооч
28. Дашнямын Цэрмаа - Гэгээт багийн малчин

**Чандмань сум**

29. Гэндэнгийн Долгорсүрэн - 2-р багийн малчин

**Шарга сум**

30. Дамдинсүрэнгийн Энхсувд - Улаантуг багийн малчин
31. Даваагийн Оюунцэцэг - Хамтын хүч багийн малчин

**Есөнбулаг сум**

32. Ваашлав Мөнхжаргал - Гэрийн ажилтай
33. Рагчаагийн Гарамжав -Гэрийн ажилтай
34. Ядамсүрэнгийн Гармаа - Гэрийн ажилтай
35. Базаррагчаагийн Доржханд - Гэрийн ажилтай
36. Дамбахүүгийн Ариунаа - ХЭАА-д
37. Жамсрангийн Бурма - Барилгачин
38. Зулзагдын Шагж - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 124** **Улаанбаатар хот**

**Говьсүмбэр аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх"одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Говьсүмбэр аймгийн харьяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх"одонгоор шагнасугай.

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

**Сүмбэр сум**

1. Хайдавын Баярбилэг - Гэрийн ажилтай
2. Александрын Бямбасүрэн - Гэрийн ажилтай
3. Бямбаагийн Лхамсүх - Гэрийн ажилтай
4. Очирпүрэвийн Одончимэг - Гэрийн ажилтай
5. Доржийн Оюунгэрэл - Гэрийн ажилтай
6. Ичинхорлоогийн Ягаанцэцэг - Гэрийн ажилтай

**Шивээговь сум**

7. Ичинхорлоогийн Норжинсүрэн - Гэрийн ажилтай

**Баянтал сум**

8. Лувсандамдингийн Өнө-Өлзий - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 125** **Улаанбаатар хот**

### Дархан-Уул аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Дархан-Уул аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

### "АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

**Дархан сум**

1. Цээлэйгийн Оюун - Гэрийн ажилтай

**Шарын гол сум**

2. Хатапын Тамара - Гэрийн ажилтай

### "АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

**Дархан сум**

1. Дэмчигсүрэнгийн Алгирмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
2. Балдангийн Алтантуяа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
3. Жаргалын Алтантуяа - Малчин
4. Дугарсүрэнгийн Алтанцэцэг - Гэрийн ажилтай
5. Мөнхжаргалын Бадамцэцэг - Гэрийн ажилтай
6. Югээдоржийн Болорсайхан - "Дарханы дулааны цахилгаан станц" ХК-ийн ажилчин
7. Туяагийн Гантуяа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
8. Цэрэнбалжирын Дагиймаа - Гэрийн ажилтай
9. Чимэдийн Дулмаа - Гэрийн ажилтай
10. Баатарын Дэлгэр - Малчин
11. Норовын Жавзансосорбурам - Гэрийн ажилтай
12. Хүрхэбайгийн Жамила - Гэрийн ажилтай
13. Ядамын Жаргалсайхан - Гэрийн ажилтай
14. Пүрэвжавын Ичинхорлоо - Гэрийн ажилтай
15. Ядамын Лина - Малчин
16. Гомбосүрэнгийн Лхагвачулуун - Гэрийн ажилтай
17. Доржпаламын Мөнбиш -23 дугаар цэцэрлэгт багш
18. Гэсэржавын Мөнхтуяа - Гэрийн ажилтай
19. Лочинжавын Мягмарсүрэн - Гэрийн ажилтай
20. Бямбаагийн Нарантуяа - Гэрийн ажилтай
21. Самбуугийн Наранцэцэг - Гэрийн ажилтай
22. Лочингийн Нордэрмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
23. Чүлтэмийн Нямдэлгэр - Гэрийн ажилтай
24. Тэгшээгийн Оюун - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
25. Уртнасангийн Оюунцэцэг - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
26. Дугэржавын Оюунчимэг - Гэрийн ажилтай
27. Жамъяншаравын Поовжий - Гэрийн ажилтай
28. Довчингийн Үрмээ - Гэрийн ажилтай
29. Алагийн Цогзолмаа - Гэрийн ажилтай
30. Цээпилийн Цэрмаа -Гэрийн ажилтай

**Хонгор сум**

31. Цэрэнгийн Буниа - Гэрийн ажилтай
32. Гонгорын Оюунцэцэг - Гэрийн ажилтай
33. Равдангийн Цэрмаа - 14-р сургуулийн үйлчлэгч

**Орхон сум**

34. Цэвээний Зинэ - Гэрийн ажилтай

**Шарын гол сум**

35. Мустафагийн Дидар - Гэрийн ажилтай
36. Өмирзалын Жанаргүл - Гэрийн ажилтай
37. Дондовсамбуугийн Жандалмаа - Гэрийн ажилтай
38. Сэсээрийн Нарантуяа - Гэрийн ажилтай
39. Нансалын Туяа - Гэрийн ажилтай
40. Чойгоогийн Энхтайван - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 12-ны өдөр — Дугаар 70 — Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын сайн малчин шалгаруулах журам"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, "Улсын тэргүүний малчдын бүлэг шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор, "Улсын тэргүүний фермер шалгаруулах журам"-ыг 3 дугаар хавсралт ёсоор, "Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын тэргүүний тариаланч шалгаруулах журам"-ыг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус баталж, 2009 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Улсын сайн малчин, улсын тэргүүний малчдын бүлэг, Улсын тэргүүний фермер, Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын тэргүүний тариаланчийг шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 150 дугаар тогтоол, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 219 дүгээр тогтоол, "Журамд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоол, "Журамд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2006 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоол, "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах тухай Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 9 дүгээр тогтоол, "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах журамд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 33 дугаар тогтоолыг 2009 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД** — **Т.БАДАМЖУНАЙ**

**Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

## УЛСЫН САЙН МАЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 15 хүртэлх малчныг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Улсын сайн малчин"-аар жил бүр шалгаруулна.

3. "Улсын сайн малчин" цол, шагнал олгох асуудлыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

### Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

4. "Улсын сайн малчин"-аар тодорхойлогдож байгаа малчин дараахь нийтлэг шаардлага хангасан байна:

4.1. мал сүргээ даатгалд хамруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамжийг тогтмол төлсөн байх;

4.2. малгүй өрхийг малжуулах, мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл эрхлэх зэргээр шинээр ажлын байр бий болгон өрхийн орлогыг нэмэгдүүлж, хөдөөд ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан байх;

4.3. мал сүргээ эрүүлжүүлэх, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан эрүүл сүргэтэй болсон байх;

4.4. мал бүр нь хувийн дугаар, эсхүл тамгатай, үржилд ашиглаж байгаа малын анги, ашиг шимийн гарц, чанар нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон байх;

4.5. үржлийн албаны болон хэрэглэгчийн захиалгаар үржлийн мал бойжуулж худалдсан байх;

4.6. өөрийн мал маллагааны арга туршлагыг залуу малчдад эзэмшүүлэх талаар санаачилга гарган ажиллаж 2-оос доошгүй шавь малчинтай болсон байх;

4.7. малчин өрхийн хүн бүр эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамрагдаж шимтгэлийг нь тогтмол төлсөн байх.

5. "Улсын сайн малчин"-аар тодорхойлогдох малчин дор дурдсан шалгуур үзүүлэлт хангасан байна:

5.1. бодод шилжүүлснээр 150-иас доошгүй малтай, сүүлийн 3 жил дараалан хорогдол гаргаагүй байх;

5.2. хээлтэгч малаа жил бүр тогтвортой өсгөж, түүний нийт сүрэгт эзлэх хувийн жин бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувьд хүрсэн байх;

5.3. оны эхний 100 хээлтэгч мал тутмаас бойжуулсан төлийн тоо тухайн жилийн улсын дунджаас илүү, сүүлийн гурван жил дараалан өссөн байхаас гадна хээлтэгч тутмаас төл бойжуулсан байх;

5.4. мал үржүүлгийн ажилд орчин үеийн дэвшилтэт арга технологийг хэрэглэж, жил бүр үйлдвэрлэсэн махны хэмжээ нь хонин толгойд шилжүүлсэн оны эхний нэг мал тутмаар тооцоход жил бүр нэмэгдсэн байх;

5.5. нэг малаас ашигласан ашиг шимийн гарц нь тухайн үүлдэр, омгийн ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр, үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгч нь орон нутгийн мал үржлийн нэгж, албаар баталгаажсан байх;

5.6. нийт сүрэгт эзлэх ямааны тоо өндөр уул, говийн алтай муж бусаас бусад муж, бүсэд 25.0 хувиас ихгүй байх;

5.7. ойт хээрийн бүсэд хонин толгойд шилжүүлснээр нэг малд 50 кг, өндөр уулын бүсэд 20 кг, тал хээрийн бүсэд 40 кг, говийн бүсэд 5 кг өвстэй тэнцэхүйц хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх;

5.8. тухайн нутагт үе залгамжлан мал маллаж байгаа, бэлчээр нутгийн маргаангүй, малын тоо нь бэлчээрийн даац, багтаамжаас хэтрээгүй, өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэр дэх булаг, шандын эхийг хашиж хамгаалсан, бэлчээрийг талхагдлаас хамгаалах арга хэмжээ авсан байх;

5.9. малаа үржилд худалдах, аж ахуйн хэрэгцээнд борлуулах, ажлын байр шинээр бий болгох зэргээр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

5.10. өөрийн өмчлөл, эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хашаатай, худаг, уст цэгтэй, түүнийгээ засч тохижуулсан байх.

**Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим**

6. Аймаг, нийслэлийн сайн малчин болсноос хойш хоёроос доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан малчныг "Улсын сайн малчин" цол, шагнал олгуулахаар тодорхойлно.

7. "Улсын сайн малчин"-аар тодорхойлох малчны талаархи асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэн 2 хүртэл малчныг шалгаруулан тодорхойлно.

8. Тодорхойлолт, бусад баталгаажсан бичиг баримтыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хянан үзэж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн хамгийн өндөр үзүүлэлттэй 3 хүртэл малчныг "Улсын сайн малчин"-аар шалгаруулахаар бичиг баримтыг нь шалган баталгаажуулж, жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9. "Улсын сайн малчин"-аар шалгаруулахаар тодорхойлохдоо дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

9.1. малчны товч анкет (энэхүү журмын 1 дүгээр хавсралт);

9.2. ажлын үзүүлэлт (энэхүү журмын 2 дугаар хавсралт);

9.3. баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл;

9.4. сум, дүүрэг, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, санал дүгнэлт, аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлт;

9.5. холбогдох байгууллагаас гаргасан баталгаа, тодорхойлолт (энэхүү журмын 3 дугаар хавсралт);

9.6. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь шалгасан дүгнэлт.

10. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь улсын сайн малчин цол олгуулахаар бүрдүүлж ирүүлсэн тодорхойлолт, материалыг хянан үзэж шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана. Энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий 15 хүртэл малчны, үүний дотор нэгээс доошгүй тэмээчний материалыг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, саналаа Засгийн газарт оруулна.

11. Малын тоо, бүтээгдэхүүний дүнд худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

12. "Улсын сайн малчин"-аар зөвхөн нэг удаа шагнана. "Улсын сайн малчин" шагналыг Улсын аварга малчинтай адилтган үзэх тул урьд нь ийм шагнал авсан малчныг дахин шалгаруулахгүй.

**Дөрөв. Шагнал олгох**

13. "Улсын сайн малчин" тус бүрийг "Улсын сайн малчин"-ы цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, дурсгалын мөнгөн цар, 1.0 (нэг) сая төгрөгөөр шагнана. Үнэмлэх, энгэрийн тэмдэг, дурсгалын мөнгөн цар хийлгэх, худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

14. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө Засгийн газрын төлөөлөгч газар дээр нь гардуулна.

"Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 1 дүгээр хавсралт

## "УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

Цээж зураг /6x4/-ийн хэмжээтэй

он сар өдөр

| | | |
|---|---|---|
| 1 | Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр | |
| 2 | Ургийн овог | |
| 3 | Эцгийн /эх/ нэр | |
| 4 | Нэр | |
| 5 | Төрсөн он, нас, хүйс | |
| 6 | Боловсрол | |
| 7 | Ам бүлийн гишүүдийн тоо, тэдний эрхэлж байгаа ажил | |
| 8 | Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил | |
| 9 | Малчнаар ажилласан хугацаа | |
| 10 | Төр, засгаас авсан шагнал, огноо | |
| 11 | Аймгийн сайн малчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар | |

"Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 2 дугаар хавсралт

## "УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ............АЙМГИЙН ............СУМЫН МАЛЧИН ........... -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

он сар өдөр

| Үзүүлэлт | Малын төрөл | Онууд | | |
|---|---|---|---|---|
| | | .. он | .. он | .. он |
| Нэг. Малын төрөл, тоо | | | | |
| Малын үүлдэр омог | | | | |
| 1. Оны эхний мал /бодод шилжүүлснээр/ | Бүгд | | | |
| 2. Оны эхний мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 3. Хээлтэгч | Бүгд | | | |
| Үүнээс: | Ингэ | | | |
| | Гүү | | | |
| | Үнээ | | | |
| | Эм хонь | | | |
| | Эм ямаа | | | |
| 4. Хээлтүүлэгч | Бүгд | | | |
| Үүнээс: | Буур | | | |
| | Азрага | | | |
| | Бух | | | |
| | Хуц | | | |
| | Ухна | | | |
| 5. Бойжуулсан төл | Бүгд | | | |
| Үүнээс: | Ботго | | | |
| | Унага | | | |
| | Тугал | | | |
| | Хурга | | | |
| | Ишиг | | | |
| 6. Зах зээлд борлуулсан мал | Бүгд | | | |
| | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 7. Үржилд худалдсан мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 8. Малжуулахад өгсөн мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 9. Зүй бусаар хорогдсон мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 11. Оны эцэст тоологдсон мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 12. Оны эцэст байгаа хээлтэгч | Бүгд | | | |
| Үүнээс: | Ингэ | | | |
| | Гүү | | | |
| | Үнээ | | | |
| | Эм хонь | | | |
| | Эм ямаа | | | |
| 13. Хээлтүүлэгчийн тохироо | Буур | | | |
| | Азрага | | | |
| | Бух | | | |
| | Хуц | | | |
| | Ухна | | | |
| Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал | | | | |
| 14. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг амьдын жингээр/ | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 15. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | Тэмээний ноос, кг | | | |
| | Хонины ноос, кг | | | |
| | Ямааны ноолуур, кг | | | |
| | Мах үйлдвэрлэл кг | | | |
| | Сүү,литр | | | |
| 16.Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого /мянган төгрөг/ Үүнээс: | Бүгд | | | |
| | Мал борлуулснаас | | | |
| | Махнаас | | | |
| | Ноос, ноолуураас | | | |
| | Сүүнээс | | | |
| | Арьс, ширнээс | | | |
| | Бусад | | | |
| 17.Өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл, тн | Өвс | | | |
| | Гар тэжээл | | | |
| | Хужир, шүү | | | |
| 18. Хадлангийн талбай | Талбайн хэмжээ, $м^2$ | | | |
| | Авсан ургац, тн | | | |
| 19.Хашаа, худаг | Хашааны тоо | | | |
| | Багтаамж $м^3$ | | | |
| | Худгийн тоо | | | |
| | Хүчин чадал л/сек | | | |
| 20. Хөрөнгө оруулалт | мян.төгрөг | | | |
| 21. Татвар төлөлт | Төгрөгөөр | | | |
| 22. Малын даатгал | Даатгуулсан малын тоо | | | |
| | Төлсөн хураамж | | | |
| 23 Эрүүл мэндийн даатгал | Төгрөгөөр | | | |
| 24.Нийгмийн даатгалын шимтгэл | Төгрөгөөр | | | |

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

―――――――― аймаг /нийслэл/-ийн ―――――――――― сум /дүүрэг/-ын ――――――баг /хороо/- ны Засаг дарга ――――――――――――――

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн ――――――――――

"Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 3 дугаар хавсралт

**"УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ........АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН......СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ............ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГАА**

он сар өдөр

| № | Баталгаа гаргасан байгууллага, албан тушаалтан | Журмын баталгаажуулах үзүүлэлт | Баталгааны материалын он, сар, өдөр, дугаар | Гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|---|---|
| 1 | Сум, дүүргийн Засаг дарга | 4.1, 4.2, 4.6, 4.7, 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.6, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11 | | |
| 2 | Сум, дүүргийн мал аж ахуйн асуудал хариуцсан ажилтан, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний нэгж, орон нутгийн мал эмнэлэг, үржлийн улсын хяналтын байцаагч | 4.3, 4.4, 4.5, 5.4, 5.5, 5.6 | | |
| 3 | Сум, дүүргийн татвар, даатгалын алба | 4.1, 4.7 | | |
| 4 | Баг, хорооны Засаг дарга | 4.2, 4.6, 5.7, 5.8, 5.9, 5.11 | | |
| 5 | Хуулийн байгууллага | Гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй эсэх | | |

Тайлбар:

1.Холбогдох баримтыг хавсаргаагүй бол баталгаа хүчингүйд тооцогдоно.
2. Дээрх хавсралтад заасан үзүүлэлт бүрээр тус, тусад нь баталгаа гаргана.

———————————— сум/дүүрэг/-ын Засаг дарга ————————————

Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## УЛСЫН ТЭРГҮҮНИЙ МАЛЧДЫН БҮЛЭГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, бэлчээрийг зохистой ашиглах, хөдөөд ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах болон нийгэмд оруулж байгаа малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоо, хамтлаг /цаашид "малчдын бүлэг" гэх/-ийн хувь нэмрийг үнэлэн урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 3 хүртэлх малчдын бүлгийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ээр жил бүр шалгаруулна.

3. "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ийг шалгаруулан шагнах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

### Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

4. "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ээр тодорхойлогдож байгаа малчдын бүлэг нь дараах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан байна:

4.1. малчдын бүлгийн үйл ажиллагаа нь тогтмолжсон, албан ёсны бүртгэлтэй байх;

4.2. хээлтэгчийн тоо тогтвортой нэмэгдэж, нийт сүрэгт эзлэх хувийн жин бог малд 52, бод малд 35-аас доошгүй хувьд хүрсэн байх;

4.3. оны эхний 100 хээлтэгч мал тутмаас бойжуулсан төлийн тоо тухайн жилийн улсын дунджаас илүү байх;

4.4. мал үржүүлгийн ажилд орчин үеийн дэвшилтэт арга технологийг хэрэглэж, дундажаар хонин толгойд шилжүүлснээр тооцоход малчдын бүлгийн оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах жил дараалан өссөн байх;

4.5. нэг малаас ашигласан ашиг шимийн гарц нь бүлгийн дунджаар тухайн үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр, үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгч нь орон нутгийн мал үржлийн нэгж, албаар баталгаажсан байх;

4.6. өндөр уул, говийн алтай муж бүс нутгаас бусад муж, бүсэд нийт сүрэгт эзлэх ямааны тоо 25.0 хувиас ихгүй байх;

4.7. мал сүргээ төрөлжүүлэн үржүүлэхийн зэрэгцээ эрүүлжүүлж, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан эрүүл сүрэгтэй болсон байх;

4.8. үржилд ашиглаж байгаа мал бүр нь хувийн дугаартай, эсхүл тамгатай, малын анги, ашиг шимийн гарц, чанар нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон байх;

4.9. мал сүргийг байгалийн эрсдлээс хамгаалах зорилгоор хүрэлцэхүйц хэмжээний өвс, тэжээлийг бүлгийн гишүүд жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх;

4.10. бүлгийн гишүүдийн малын тоо бэлчээрийн даац багтаамжаас хэтрээгүй, Газрын тухай хуульд заасны дагуу бэлчээрийг гэрээгээр ашиглахаар шийдвэр гаргуулсан, газрын зөрчилгүй, бэлчээрийг сэргээн сайжруулах, талхагдлаас хамгаалахад хөрөнгө оруулалт хийж үр дүнд хүрсэн байх;

4.11. өвөлжөө, хаваржааны ойролцоо 10–аас доошгүй га хадлангийн талбайг хаших, услах, цас, мөс, бороонь ус тогтоох, бордох, нэг болон олон наст ургамлын үр тариалах зэргээр ашиглалтыг сайжруулж ургацыг нэмэгдүүлсэн байх;

4.12. мал аж ахуйгаас бусад чиглэлээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа (жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, гар урлал, оёдол гэх мэт) явуулж гишүүдийн өрхийн орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсан байх;

4.13. малаа үржилд худалдах, аж ахуйн хэрэгцээнд борлуулах, ажлын байр шинээр бий болгох зэргээр эдийн засгийн эргэлтэд оруулж, малын тоог тогтвортой байлгаж, чанарыг нь сайжруулахад хөрөнгө оруулалт хийсэн байх;

4.14. жил бүр бүлгийн гишүүдийн хүчээр өвөлжөө, хаваржааны хашаа, хороо, худаг, уст цэгийг засварлан тохижуулж, шинээр барьж байгуулах ажлыг хийж заншсан байх;

4.15. бүлгийн гишүүд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамрагдаж, шимтгэлийг нь тогтмол төлсөн байх;

4.16. бүлгийн гишүүдийн дундын өмчлөлийн сан бий болгосон, түүнийгээ арвижуулах талаар үр дүнтэй ажилласан байх.

**Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим**

5. Аймаг, нийслэлийн тэргүүний малчдын бүлэг болсноос хойш хоёроос доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын бүлгийг "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ээр шалгаруулахаар тодорхойлно.

6. "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ээр тодорхойлох материалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, тодорхойлолт, холбогдох материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

7. Тодорхойлолт, баталгаажсан бусад бичиг баримтыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хянан үзэж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн хамгийн өндөр үзүүлэлттэй малчдын 1 бүлгийг "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ээр шалгаруулахаар бичиг баримтыг нь бүрдүүлэн 1 дүгээр сарын 5-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8. "Улсын тэргүүний малчдын бүлэг"-ээр шалгаруулахаар тодорхойлохдоо дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

8.1. малчдын бүлгийн тодорхойлолт (энэхүү журмын 1 дүгээр хавсралт);

8.2. ажлын үзүүлэлт (энэхүү журмын 2 дугаар хавсралт);

8.3. сум, дүүрэг, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, санал дүгнэлт, аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлт;

8.4. холбогдох байгууллагаас гаргасан баталгаа, тодорхойлолт (энэхүү журмын 3 дугаар хавсралт);

8.5. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь шалгасан дүгнэлт.

9. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь Улсын тэргүүний малчдын бүлгээр шалгаруулахаар ирүүлсэн тодорхойлолт, материалыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий 3 хүртэлх малчдын бүлгийн материалыг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн саналаа Засгийн газарт оруулна.

10. Малын тоо, бүтээгдэхүүний дунд худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

11. Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоо, хамтлагийг «Улсын тэргүүний малчдын бүлэг»-ээр зөвхөн нэг удаа шагнана.

**Дөрөв. Шагнал олгох**

12. "Улсын тэргүүний малчдын бүлэг" тус бүрийг өргөмжлөл, дурсгалын цом, 3.0 (гурван) сая төгрөгөөр шагнана. Өргөмжлөл, дурсгалын цом худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

13. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө Засгийн газрын төлөөлөгч газар дээр нь гардуулна.

"Улсын тэргүүний малчдын бүлэг шалгаруулах журам"-ын 1 дүгээр хавсралт

**"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ МАЛЧНЫ БҮЛЭГ" /НӨХӨРЛӨЛ, ХОРШОО, ХАМТЛАГ/-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА МАЛЧДЫН БҮЛГИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

он сар өдөр

| | | |
|---|---|---|
| 1 | Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр | |
| 2 | Бүлэг, нөхөрлөл, хоршоо,хамтлагийн нэр | |
| 3 | Байгуулагдсан огноо | |
| 4 | Улсын бүртгэлийн дугаар | |
| 5 | Регистрийн дугаар | |
| 6 | Гишүүдийн тоо | |
| 7 | Явуулж байгаа үйл ажиллагааны чиглэл | |
| 8 | Дундын өмчлөлийн сангийн хуримтлал /сая.төг/ | |
| 9 | Төр, засгаас авсан шагнал, огноо | |
| 10 | Аймаг, нийслэлийн тэргүүний малчны бүлгээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар | |

"Улсын тэргүүний малчдын бүлэг шалгаруулах журам"-ын 2 дугаар хавсралт

**"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ МАЛЧДЫН БҮЛЭГ"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА...........АЙМГИЙН ...........СУМЫН ....... МАЛЧДЫН БҮЛГИЙН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

он сар өдөр

| Үзүүлэлт | Малын төрөл | Онууд | | |
|---|---|---|---|---|
| | | .. он | .. он | .. он |
| Нэг. Малын төрөл, тоо, малын үүлдэр омог, | | | | |
| 1. Оны эхний мал /бодод шилжүүлснээр/ | Бүгд | | | |
| 2. Оны эхний мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 3. Хээлтэгч | Бүгд | | | |
| Үүнээс: | Ингэ | | | |
| | Гүү | | | |
| | Үнээ | | | |
| | Эм хонь | | | |
| | Эм ямаа | | | |
| 4. Хээлтүүлэгч | Бүгд | | | |
| Үүнээс: | Буур | | | |
| | Азрага | | | |
| | Бух | | | |
| | Хуц | | | |
| | Ухна | | | |
| 5. Бойжуулсан төл | Бүгд | | | |
| Үүнээс: | Ботго | | | |
| | Унага | | | |
| | Тугал | | | |
| | Хурга | | | |
| | Ишиг | | | |
| 6. Зах зээлд борлуулсан мал | Бүгд | | | |
| | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 7. Үржилд худалдсан мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. Малжуулахад өгсөн мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 9. Зүй бусаар хорогдсон мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 10. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 11. Оны эцэст тоологдсон мал | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 12. Цөм сүргийн малын тоо | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 13. Оны эцэст байгаа хээлтэгч | Бүгд | | | |
| Үүнээс: | Ингэ | | | |
| | Гүү | | | |
| | Үнээ | | | |
| | Эм хонь | | | |
| | Эм ямаа | | | |
| 14. Хээлтүүлэгчийн тохироо | Буур | | | |
| | Азрага | | | |
| | Бух | | | |
| | Хуц | | | |
| | Ухна | | | |
| Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал (бүлэг, нөхөрлөлийн дунджаар) | | | | |
| 15. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг, нядалгын жингээр/ | Бүгд | | | |
| Үүнээс: | Тэмээ | | | |
| | Адуу | | | |
| | Үхэр | | | |
| | Хонь | | | |
| | Ямаа | | | |
| 16. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | Тэмээний ноос, кг | | | |
| | Хонины ноос, кг | | | |
| | Ямааны ноолуур, кг | | | |
| | Мах үйлдвэрлэл кг | | | |
| | Сүү,литр | | | |
| 17.Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого /мянган төгрөг/ Үүнээс: | Бүгд | | | |
| | Мал борлуулснаас | | | |
| | Махнаас | | | |
| | Ноос, ноолуураас | | | |
| | Сүүнээс | | | |
| | Арьс, ширнээс | | | |
| | Бусад | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 18.Өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл, тн | Өвс | | | |
| | Гар тэжээл | | | |
| | Хужир, шүү | | | |
| 19. Хадлангийн талбай | Талбайн хэмжээ, $м^2$ | | | |
| | Авсан ургац, тн | | | |
| 20.Хашаа, худаг | Хашааны тоо | | | |
| | Багтаамж $м^3$ | | | |
| | Худгийн тоо | | | |
| | Хүчин чадал л/сек | | | |
| 21. Хөрөнгө оруулалт | мян.төгрөг | | | |
| 22.Шинээр бий болгосон ажлын байр | Тоо | | | |
| 23. Ажиллаж буй хүн | Хүний тоо | | | |
| 24. Орлогын татвар төлөлт | Төгрөгөөр | | | |
| 25. Малын даатгал | Даатгуулсан малын тоо | | | |
| | Төлсөн хураамж | | | |
| 26.Үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон орлого | мян.төг | | | |
| 27. Нэг өрхийн орлого | мян.төг | | | |
| 28.Бүлэг, нөхөрлөлийн нэг гишүүний сарын дундаж орлого | Төгрөгөөр | | | |
| 29.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдал | Төгрөгөөр | | | |

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

——————— аймаг /нийслэл/-ийн ——————— сум /дүүрэг/-ын ————баг /хороо/-ийн Засаг дарга ———————————

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн ———————————

"Улсын тэргүүний малчдын бүлэг шалгаруулах журам"-ын 3 дугаар хавсралт

**"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ МАЛЧДЫН БҮЛЭГ"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ............АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН......СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ......БҮЛГИЙН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГАА**

он сар өдөр

| № | Баталгаа гаргасан байгууллага, албан тушаалтан | Журмын баталгаажуулах үзүүлэлт | Баталгаа болох материалын он, сар, өдөр, дугаар | Гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|---|---|
| 1 | Сум, дүүргийн Засаг дарга | 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5, 4.6, 4.7, 4.9, 4.10, 4.11, 4.12, 4.13, 4.14, 4.15 | | |
| 2 | Сум, дүүргийн мал аж ахуйн асуудал хариуцсан ажилтан, мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний нэгж, орон нутгийн мал эмнэлэг, үржлийн улсын хяналтын байцаагч | 4.3, 4.4, 4.5, 4.6, 4.7, 4.8, 4.13 | | |
| 3 | Сум, дүүргийн татвар, даатгалын алба | 4.1, 4.15, 4.16 | | |
| 4 | Хуулийн байгууллага | Гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй эсэх | | |

Тайлбар:

1.Холбогдох баримтыг хавсаргаагүй бол баталгаа хүчингүйд тооцогдоно.

2. Дээрх хавсралтад заасан үзүүлэлт бүрээр тус, тусад нь баталгаа гаргана.

3. Малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааны талаарх танилцуулга, холбогдох мэдээллийг тодорхой гаргаж, тэдгээрийн бүртгэлийн гэрчилгээний хуулбарын хамт ирүүлнэ.

——————————— сум/дүүрэг/-ын

Засаг дарга———————————

Засгийн газрын 2009 оны 70 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

## УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ФЕРМЕР ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэн өндөр ашиг шимт мал, амьтан өсгөн үржүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх болон нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 3 хүртэлх эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Улсын тэргүүний фермер"-ээр жил бүр шалгаруулна.

3. "Улсын тэргүүний фермер"-ээр шалгаруулан шагнах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

**Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл**

4. "Улсын тэргүүний фермер"-ээр тодорхойлогдож байгаа эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь дараах нийтлэг шаардлага хангасан байна:

4.1. байгаль орчинд халгүй аргаар үйл ажиллагаа эрхэлж, орчны ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжилтийг бүрэн шийдвэрлэсэн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

4.2. мал, амьтныг эрсдлээс хамгаалах даатгалд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж тогтмол төлсөн байх;

4.3. мал, амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан эрүүл сүрэгтэй болсон байх;

4.4. мал нэг бүр нь хувийн дугаартай, үржилд ашиглаж байгаа малын анги, ашиг шимийн гарц, чанар нь мэргэжлийн байгууллагаар баталгаажсан байх;

4.5. үржлийн албаны болон хэрэглэгчийн захиалгаар үржлийн мал, гахай, шувуу бойжуулж худалдсан байх;

4.6. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамрагдаж, шимтгэлийг тогтмол төлсөн байх.

Гурав. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдэд тавих шалгуур үзүүлэлт

5. "Улсын тэргүүний фермер"-ээр тодорхойлогдож байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь энэ журмын 4-т заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлт хангасан байна:

5.1. өндөр ашиг шимийн чиглэлээр дагнан төрөлжсөн нэг үүлдрийн мал, амьтныг сонгон үржүүлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь жил дараалан өссөн, хорогдол гаргаагүй байх;

5.2. тухайн үүлдрийн мал, амьтны арчилгаа маллагааны технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжтэй байх;

5.3. тодорхой аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлдэг байх;

5.4. мал, амьтны чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар сайжруулах чиглэлээр шинэ техник, тоног төхөөрөмж, дэвшилтэт арга технологи нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хүрсэн байх;

5.5. саалийн болон махны чиглэлийн аж ахуй эрхлэгч иргэн 20-иос доошгүй га, аж ахуйн нэгж 100-гаас доошгүй га газар хашиж хамгаалах, худаг гаргах, усжуулах, нэг болон олон наст ургамал тариалж таримал бэлчээр бий болгох, хадлан, дарш, тэжээл бэлтгэх зэргээр газраа үр ашигтай ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

5.6. үржилд ашиглаж байгаа мал, амьтан бүр удам гарваль, ашиг шимийн бүртгэлтэй байх;

5.7. тэжээл бэлтгэх тоног төхөөрөмжтэй, өөрийн хэрэгцээт тэжээлийн 40-өөс доошгүй хувийг бэлтгэдэг байх;

5.8. саалийн чиглэлийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 25, аж ахуйн нэгж 50-иас доошгүй стандартын нэг болон түүнээс дээш ангийн шаардлага хангасан үнээтэй, зохиомол аргаар хээлтүүлэг хийдэг, нэг үнээнээс жилд дунджаар 4500-гаас доошгүй литр сүү саасан, сүүний үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

5.9. махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 50, аж ахуйн нэгж 100–гаас доошгүй үнээтэй, оны эхний нэг үхрээс 50 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

5.10. махны чиглэлийн хонь үржүүлж байгаа иргэн 300, аж ахуйн нэгж 500–гаас доошгүй эм хоньтой, оны эхний нэг хониноос 7.5 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

5.11. гахайн аж ахуй эрхэлж байгаа иргэн 10, аж ахуйн нэгж 50-иас доошгүй үндсэн мэгжтэй, мэгж бүрээс жилд 20-иос доошгүй торой бойжуулж, эхний жилд 2.0 тонноос доошгүй мах үйлдвэрлэсэн, мах үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

5.12. шувуу үржүүлж байгаа өрх, аж ахуйн нэгж нь оны эхэнд 20000-аас доошгүй өндөглөгчтэй, нэг өндөглөгчөөс жилд 280-аас доошгүй өндөг үйлдвэрлэсэн байх.

**Дөрөв. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим**

6. Аймаг, нийслэлийн тэргүүний фермер

болсноос хойш хоёроос доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан фермерийг "Улсын тэргүүний фермер"-ээр шалгаруулахаар тодорхойлно.

7. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан фермер, аж ахуйн нэгжийн материалыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн тодорхойлолт гаргаж, холбогдох материалын хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

8. Тодорхойлолт, бусад баталгаажсан бичиг баримтыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хянан үзэж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн хамгийн өндөр үзүүлэлттэй эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг "Улсын тэргүүний фермер"-ээр шалгаруулахаар тодорхойлолт, бичиг баримтыг нь бүрдүүлж жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9. Улсын тэргүүний фермерээр шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримт бүрдүүлсэн байна:

9.1. фермерийн анкет (энэхүү журмын 1 дүгээр хавсралт);

9.2. ажлын үзүүлэлтүүд (энэхүү журмын 2-4 дүгээр хавсралт);

9.3. сум, дүүрэг, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, санал дүгнэлт, аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлт;

9.4. холбогдох байгууллагаас гаргасан баталгаа, тодорхойлолт (энэхүү журмын 5 дугаар хавсралт);

9.5. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь шалгасан дүгнэлт.

10. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь улсын тэргүүний фермерээр шалгаруулахаар бүрдүүлж ирүүлсэн тодорхойлолт, материалыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий гурав хүртэлх эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерийн материалыг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн саналаа Засгийн газарт оруулна.

11. Малын тоо, бүтээгдэхүүний дүнд худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг тооцохгүй.

12. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг "Улсын шилдэг фермер"-ээр зөвхөн нэг удаа шагнана.

**Тав. Шагнал олгох**

13. "Улсын тэргүүний фермер" тус бүрийг өргөмжлөл, дурсгалын цом, 3.0 (гурван) сая төгрөгөөр шагнана. Өргөмжлөл, дурсгалын цом худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

14. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө Засгийн газрын төлөөлөгч газар дээр нь гардуулна.

**"Улсын тэргүүний фермер шалгаруулах журам"-ын 1 дүгээр хавсралт**

"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ФЕРМЕР"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА ФЕРМЕРИЙН ТОВЧ АНКЕТ

Цээж зураг /6х4/-ийн хэмжээтэй

он сар өдөр

| | | |
|---|---|---|
| 1 | Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг,хорооны нэр | |
| 2 | Ургийн овог | |
| 3 | Эцэг /эх/-ийн нэр | |
| 4 | Нэр | |
| 5 | Төрсөн он, нас, хүйс | |
| 6 | Боловсрол | |
| 7 | Ам бүлийн гишүүдийн тоо, эрхэлж байгаа ажил | |
| 8 | Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил | |
| 9 | Үүнээс: малчнаар ажилласан хугацаа | |
| 10 | Төр, засгаас авсан шагнал, огноо | |
| 11 | Аймаг, нийслэлийн тэргүүний фермерээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар | |

"Улсын тэргүүний фермер шалгаруулах журам"-ын 2 дугаар хавсралт

## "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ФЕРМЕР"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ................АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН ...........СУМ ДҮҮРЭГ)-ЫН СААЛИЙН ҮХРИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ ............ НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

он сар өдөр

| Үзүүлэлт | Онууд | | |
|---|---|---|---|
| | .. он | .. он | .. он |
| 1. Үржүүлж байгаа үхрийн үүлдэр | | | |
| 2. Оны эхэнд байгаа нийт үхэр (тоо) | | | |
| Үүнээс: а/ үнээ (тоо) | | | |
| б/ бойжуулсан тугал(тоо) | | | |
| 3. Үйлдвэрлэсэн нийт сүү (тн) | | | |
| 4. Саалийн 305 хоногт нэг үнээнээс саасан сүү (литр) | | | |
| 5. Үржилд худалдсан үхрийн тоо | | | |
| Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч | | | |
| б/ өсвөр хээлтэгч | | | |
| 6. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн тоо | | | |
| 7. Зохиомлоор хээлтүүлсэн үнээний тоо | | | |
| 8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тн) | | | |
| Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэсэн:<br>а/ хүчит тэжээл (тн) | | | |
| б/ дарш (тн) | | | |
| в/ өвс (тн) | | | |
| 9. Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га) | | | |
| а/ хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн) | | | |
| б/ нэг га-гаас авсан ургац (цн) | | | |
| 10. Нэг үхэрт зарцуулсан тэжээлийн хэмжээ(тэж/н) | | | |
| 11. Үхрийн байрны багтаамж $м^2$ | | | |
| 12. Ашиглаж байгаа худгийн хүчин чадал л/сек | | | |
| 13. Оны эцэст тоологдсон нийт үхэр | | | |
| Үүнээс: үнээ /тоо/ | | | |
| 14. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг) | | | |
| 15. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг) | | | |
| 16. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг) | | | |
| 17. Малчны дундаж цалин (мян.төг) | | | |
| 18. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг) | | | |

———————————— сум /дүүрэг/-ын

Засаг дарга ————————————

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн ————————————

"Улсын тэргүүний фермер шалгаруулах журам"-ын 3 дугаар хавсралт

## "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ФЕРМЕР"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА .............АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН ..........СУМ (ДҮҮРЭГ)-ЫН МАХНЫ ҮХЭР (ХОНИНЫ)-ИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ ......... НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

он сар өдөр

| Үзүүлэлт | Онууд | | |
|---|---|---|---|
| | .. он | .. он | .. он |
| Нэг. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн ажлын үзүүлэлт | | | |
| 1. Үржүүлж байгаа үхэр (хонь)-ийн үүлдэр | | | |
| 2. Оны эхэнд байгаа нийт үхэр эсхүл хонь, тоо | | | |
| Үүнээс: а/ хээлтэгч /тоо/ | | | |
| б/ хээлтүүлэгч /тоо/ | | | |
| в/ бойжуулсан төл /тоо/ | | | |
| 3.Үйлдвэрлэсэн нийт мах /тн/ | | | |
| 4.Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг/ /нядалгын жингээр/ | | | |
| 5.Зах зээлд борлуулсан нэг үхэр эсхүл хонины дундаж амьдын жин /кг/ | | | |
| 6.Үржилд худалдсан нийт үхэр эсхүл хонины тоо | | | |
| Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч | | | |
| б/ өсвөр хээлтэгч | | | |
| 7.Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн тоо | | | |
| 8.Зохиомлоор хээлтүүлсэн малын тоо | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 9.Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ /тн/ | | | |
| Үүнээс: а/өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл /тн/ | | | |
| б/ худалдаж авсан тэжээл /тн/ | | | |
| 10.Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ /га/ | | | |
| 11.Хураан авсан нийт тэжээлийн ургамал /цн/ | | | |
| 12.Нэг га-гаас авсан ургац | | | |
| 13.Нэг малд зарцуулсан тэжээлийн хэмжээ /тэж.н/ | | | |
| 14.Хашааны багтаамж $м^2$ | | | |
| 15.Худгийн хүчин чадал л/сек | | | |
| 16.Оны эцэст тоологдсон нийт мал | | | |
| Үүнээс: а/ хээлтэгч /тоо/ | | | |
| б/ хээлтүүлэгч /тоо/ | | | |
| 17.Хөрөнгө оруулалт (мян.төг) | | | |
| 18.Жилийн борлуулалтын нийт орлого /мян.төг/ | | | |
| 19.Жилд олсон цэвэр ашиг /мян.төг/ | | | |
| 20.Нэг ажилтны дундаж цалин /мян.төг/ | | | |
| 21.Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг) | | | |

_______ сум /дүүрэг/-ын Засаг дарга ________________
Хөдөө аж ахуйн мэргэжилтэн ______________________

**"Улсын тэргүүний фермер шалгаруулах журам"-ын 4 дүгээр хавсралт**

**"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ФЕРМЕР"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА .............. АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН ............СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ГАХАЙ, ШУВУУНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ ...... НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

он сар өдөр

| Үзүүлэлт | Онууд | | |
|---|---|---|---|
| | .. он | .. он | .. он |
| Нэг. Гахайчны ажлын үзүүлэлт | | | |
| 1. Үржүүлж байгаа гахайн үүлдэр | | | |
| 2. Оны эхэнд байгаа нийт гахайны тоо | | | |
| а/ үндсэн мэгжийн тоо | | | |
| б/ үржилд ашиглах бодонгийн тоо | | | |
| в/ бойжуулсан нийт торойн тоо | | | |
| г/ нэг мэгжнээс бойжуулсан торой | | | |
| 3.Үйлдвэрлэсэн нийт гахайн мах /тн/ | | | |
| 4.Маханд борлуулсан нэг гахайн дундаж амьдын жин /кг/ | | | |
| 5. Үржилд худалдсан шалгалтын мэгжний тоо | | | |
| 6.Оны эцэст тоологдсон нийт гахай | | | |
| Үүнээс:үндсэн мэгжийн тоо | | | |
| 7. Цөм сүргийн гахайны тоо | | | |
| 8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ /тн/ | | | |
| а/ өөрийн хүчээр үйлдвэрлэсэн /тн/ | | | |
| б/ худалдан авсан тэжээл /тн/ | | | |
| 9. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг) | | | |
| 10. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг) | | | |
| 11. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг) | | | |
| 12. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг) | | | |
| Хоёр. Шувуучны ажлын үзүүлэлт | | | |
| Үзүүлэлт | онууд | | |
| | .. он | .. он | .. он |

| | | | |
|---|---|---|---|
| 1. Үржүүлж байгаа шувууны үүлдэр | | | |
| 2. Оны эхэнд байгаа нийт шувууны тоо | | | |
| Үүнээс:өндөглөгч шувууны тоо | | | |
| 3.Нийт үйлдвэрлэсэн өндөг (мян.ширхэг) | | | |
| Үүнээс: борлуулсан өндөг (мян. ширхэг) | | | |
| 4. Бойжуулсан дэгдээхэй | | | |
| 5. Үржилд худалдсан шувуу | | | |
| 6. Үйлдвэрлэсэн мах (кг) | | | |
| 7. Эх сүргийн шувууны тоо | | | |
| 8.Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тн) | | | |
| Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэж,үйлдвэрлэсэн (тн) | | | |
| - худалдан авсан тэжээл (тн) | | | |
| 9. Оны эцэст байгаа нийт шувуу | | | |
| Үүнээс: өндөглөгч шувууны тоо | | | |
| 10. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг) | | | |
| 11. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг) | | | |
| 12. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг) | | | |
| 13. Нэг ажилчны дундаж цалин (мян.төг) | | | |
| 14. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг) | | | |

Тайлбар: Үзүүлэлтийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

——————— сум /дүүрэг/-ын Засаг дарга ———————

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн ———————

"Улсын тэргүүний фермер шалгаруулах журам"-ын 5 дугаар хавсралт

**"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ФЕРМЕР"-ЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ............ АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН......СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ..........ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГАА**

он сар өдөр

| № | Баталгаа гаргасан байгууллага, албан тушаалтан | Журмын баталгаажуулах үзүүлэлт | Баталгаа болгох материалын он, сар, өдөр, дугаар | Гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|---|---|
| 1 | Сум, дүүргийн Засаг дарга | 4.1, 4.2, 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12 | | |
| 2 | Сум, дүүргийн мал аж ахуйн асуудал хариуцсан түшмэл, Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний нэгж, орон нутгийн мал эмнэлэг, үржлийн улсын хяналтын байцаагч | 4.1,4.3, 4.4,4.5,5.1, 5.2, 5.4, 5.5, 5.6,5.8,5.9, 5.10,5.11, 5.12, | | |
| 3 | Сум, дүүргийн татвар, даатгалын алба | 4.2,4.6, | | |
| 4 | Бүтээгдэхүүн худалдан авдаг аж ахуйн нэгж | 5.3 | | |
| 5 | Хуулийн байгууллага | Гэмт хэрэг,хэв журмын зөрчилтэй эсэх | | |

Тайлбар:

1.Холбогдох баримтыг хавсаргаагүй бол баталгаа хүчингүйд тооцогдоно.

2. Дээрх хавсралтад заасан үзүүлэлт бүрээр тус, тусад нь баталгаа гаргана.

3. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааны талаархи танилцуулга, холбогдох мэдээллийг тодорхой гаргаж ирүүлнэ.

——————————— сум/дүүрэг/-ын

Засаг дарга———————————

Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

## УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН, УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөрс хамгаалах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж эрчимжүүлэх, нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах болон нийгэмд оруулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хувь нэмрийг урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 8 хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн "Улсын тэргүүний тариаланч хамт олон", 15 хүртэл иргэнийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Улсын тэргүүний тариаланч"-аар жил бүр шалгаруулна. Үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжид ажиллаж байгаа тракторч-комбайнчдыг "Улсын тэргүүний тариаланч"-д хамруулан шалгаруулж болно.

3. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулан шагнах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

### Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

4. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараах шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан байна:

4.1. хамт олон нь жил бүр усалгаатай нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 250 га, усалгаагүй нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 500 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 10 га; иргэн нь усалгаатай нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 50 га, усалгаагүй нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 100 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 0.5 га-гаас доошгүй талбайд тус тус тариалалт хийж ургац хураан авсан байна;

4.2. сүүлийн 3 жил дараалан, жил бүр га тутмаас хураан авсан үр тарианы ургац нь усалгаагүй талбайд 13 цн-ээс, усалгаатай талбайд 30 цн-ээс, төмсний ургац нь усалгаагүй талбайд 160 цн-ээс, усалгаатай талбайд 200 цн-ээс, малын тэжээлийн ургац нь усалгаагүй талбайд 30 цн-ээс, усалгаатай талбайд 60 цн-ээс доошгүй байх;

4.3. сүүлийн 3 жил дараалан, жил бүр га тутмаас байцаа 250 цн-ээс, үндэс үрт ногоо 180 цн-ээс, сонгинолог ургамал 120 цн-ээс, хамгаалагдсан хөрсний 1 метр квадрат талбай тутмаас өргөст хэмх 18 кг, улаан лооль 12 кг-аас доошгүй ургац хураан авсан байх;

4.4. сүүлийн 3 жил дараалан жил бүр комбайнаар шууд хураалтад шилжүүлснээр 400 га, трактораар 1200 жишмэл га-гаас доошгүй ажил гүйцэтгэсэн байх;

4.5. хөрсний үржил шимийг хамгаалах, чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, үр тарианы үйлдвэрлэлд уриншийн эзлэх хувийн жинг багасгаж, тэжээлийн ургамлыг сэлгээнд оруулсан байх;

4.6. үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид нь эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, дараа оны тариалалтад зориулан хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үр нөөцөлсөн байх;

4.7. аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байр бий болгох, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх;

4.8. татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх;

4.9. хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний газартай болж техникийн бэлэн байдал, хангамжийг сайжруулсан байх.

### Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим

5. Аймаг, нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон, тэргүүний тариаланч болсноос хойш хоёроос доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан тариаланч хамт олон, тариаланчийг "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулахаар тодорхойлно.

6. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тодорхойлолт, холбогдох материалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор багтаан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

7. Тодорхойлолт, баталгаажсан материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хянан үзэж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, хамгийн өндөр амжилт гаргасан гурав хүртэл аж ахуйн нэгж, байгууллага, тав хүртэл тариаланчийн тодорхойлолт, холбогдох материалыг жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлнэ:

8.1. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажил байдлын талаархи сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;

8.2. сум, дүүрэг, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, санал дүгнэлт, аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлт;

8.3. энэхүү журмын хавсралтын дагуу бүрдүүлсэн сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт;

8.4. харилцагч татварын байгууллагын тодорхойлолт, орлогын татвар төлөлтийн баримт;

8.5. хөрс хамгаалах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн тухай тодорхойлолт;

8.6. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь шалгасан дүгнэлт.

9. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дүнд бусдаас худалдан авсан болон өр төлбөрт авсан бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

10. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь улсын тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланчаар шалгаруулахаар ирүүлсэн материалыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг ажлын үзүүлэлтээр нь байр эзлүүлэн энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий 8 хүртэл аж ахуйн нэгж, байгууллага, 15 хүртэл иргэний материалыг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн саналаа Засгийн газарт оруулна.

11. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар зөвхөн нэг удаа шалгаруулна.

**Дөрөв. Шагнал олгох**

12. "Улсын тэргүүний тариаланч хамт олон" тус бүрийг өргөмжлөл, дурсгалын цом, тус бүр 3.0 (гурван) сая төгрөгөөр, "Улсын тэргүүний тариаланч"-ийг цолны үнэмлэх, мөнгөн цар, энгэрийн тэмдэг, 1.0 (нэг) сая төгрөгөөр шагнана. Өргөмжлөл, дурсгалын цом, энгэрийн тэмдэг, мөнгөн цар худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

13. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө Засгийн газрын төлөөлөгч газар дээр нь гардуулна.

**"Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын тэргүүний тариаланч шалгаруулах журам"-ын хавсралт**

**"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН", "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ" ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТ**

| Үзүүлэлт | Онууд | | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | .. он | .. он | .. он | |
| 1. Тариалангийн эргэлтийн талбай, га | | | | |
| Үүнээс: -тарьсан | | | | |
| -уриншилсан | | | | |
| 2. Таримлын төрөл | | | | |
| 3. Хураан авсан ургац, тонн | | | | |
| Үүнээс: -нөөцөлсөн үр, тонн | | | | |
| -зах зээлд борлуулсан ургац тонн | | | | |
| 4. Нэг га-гийн ургац /тарьсан талбайд цн-ээр/ | | | | |
| Үүнээс: -усалгаатай талбайгаас /цн/ | | | | |
| -усалгаагүй талбайгаас /цн/ | | | | |
| 5. Нийт борлуулалт сая.төг | | | | |
| Үүнээс: -татварт сая.төг | | | | |
| -даатгалд сая.төг | | | | |
| 6. Ашиг сая. төг | | | | |
| 7. Ажлын байрны тоо | | | | |
| 8. Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн орлого | | | | |
| 9. Тракторaap гүйцэтгэсэн ажил, жишмэл га-гаар | | | | |
| 10. Комбайнаар хураасан талбай, шууд хураалтад шилжүүлсэн га-гаар, авсан ургац тонноор | | | | |

Тайлбар : Энэ хүснэгтэд зөвхөн сүүлийн 3 жилийн тариалангийн үзүүлэлтийг бичнэ. Шагнагдах үндэслэлийн талаар тодорхойлолтод дэлгэрэнгүй бичиж, холбогдох байгууллагын тодорхойлолтыг үзүүлэлт тус бүрээр бүрдүүлж ирүүлсэн байна. Дээрх хүснэгтийн 9, 10-д заасан ажлын хэмжээ нь зөвхөн тракторч-комбайнчид хамаарна.

Үзүүлэлтийг гаргасан:

Сум, дүүргийн Засаг дарга ———— —— (...............)
Мэргэжилтэн ———————————— (...............)

Хянаж баталсан:

Аймаг, нийслэлийн ХХААГ-ын дарга———— (...............)
Мэргэжилтэн———————————— (...............)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 169 | Улаанбаатар хот

**Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.1, 11.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 164 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дүрэм"-ийн "Хоёр"-т "2.7. Салбар хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэж болно." гэсэн заалт нэмсүгэй.

2. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм"-ийн 3.1-ийн "бөхчүүдийг гарын даа нар баяр наадам болохоос 7 хоногийн өмнө бүртгэж дуусгана" гэснийг "...бөхчүүдийн бүртгэлийг гарын даа нар баяр наадам болохоос хоёр хоногийн өмнө эхэлж, баяр наадмын өмнөх өдрийн 18.00 цагт дуусгана." гэж өөрчлөн найруулсугай.

3. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм"-ийн 7.4.2-ын 1 дэх өгүүлбэрийг "Сэргээш хэрэглэсэн нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол тухайн бөхийн наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах, цол, чимэг авах даваанд уг бөхөд унасан бөхчүүдийг тухайн даваанд давснаар тооцож, зохих цол, чимгийг олгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ." гэж өөрчилж, 5.5-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм"-ийн 4.1-ийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

"4.1. Хурдан морийг насны ангиллаар нь дараах зайд уралдуулна:

| | |
|---|---|
| Азарга | 22-24 км |
| Их нас | 24-26 км |
| Соёолон | 22-24 км |
| Хязаалан | 15-17 км |
| Шүдлэн | 12-14 км |
| Даага | 10-12 км". |

5. "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм"-ийн 8.4-ийн "Хүүхэдгүй уралдаж ирсэн морийг нэг байр ухраан барина." гэснийг "Хүүхэдгүй уралдаж ирсэн морийг таван байраар ухраан барина." гэж өөрчлөн найруулсугай.

6. Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 803 жилийн ой, Ардын хувьсгалын 88 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх зардалд зориулан 98.0 (ерэн найман) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С. Баярцогтод зөвшөөрсүгэй.

7. "Улаанбаатар-Лүн-Эрдэнэсант"-ын чиглэлийн авто замаас "Хүй долоон худаг" дахь хурдан морины барианы газрын үзэгчдийн талбай хүртэлх 2.3 км авто замыг 2 урсгалтай болгоход шаардагдах нийт хөрөнгийн 345.0 (гурван зуун дөчин таван) сая төгрөгийг улсын авто замын сангаас, 100.0 (нэг зуун) сая төгрөгийг нийслэлийн авто замын сангаас тус тус санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нарт, 2009 оны 7 дугаар сарын 5-ны дотор багтаан ашиглалтад оруулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

8. Орон нутгийн хамгаалалтад байгаа "Хүй долоон худаг" дахь Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаан зохион байгуулдаг газар, уралдааны замын бүрэн бүтэн байдлыг хамгаалж, тэмдэгжүүлэх, зам талбайн тохижилт, засвар, арчлалтыг тогтмол хийж, шаардагдах зардлыг нь жил бүрийн төсөвт тусгаж байхыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

9. Хамгаалалттай бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэхийг хориглож, бэлчээрээс бусад зориулалтаар ашиглуулахгүй байхыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр, Төв аймгийн Засаг дарга Ц.Энхбат нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД** **М.ЭНХБОЛД**

**3.1**. Энэ зүйлийн 117.1.-д заасан **"иргэний нэхэмжлэл гаргах эрх"** нь эдийн болон эдийн бус эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд гэм буруутай этгээдээс өөрт учирсан хохирлыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эсэхийг өөрөө шийдвэрлэх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчимд үндэслэгддэг тул хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хэнийг ч нэхэмжлэл гаргуулахаар албадах ёсгүй.

**3.2.** Мөн зүйлийн 117.2.-т заасан **"энэ хуульд заасан эрх, үүрэг"** гэдэгт хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.-т заасан эрх, 43.4.-т заасан үүрэг багтах ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх, үүрэг хамаарахгүй болно. Эдгээр эрх, үүргийг шүүх хуралдаан даргалагч хуулийн 260 дугаар зүйлийн 260.1.-д зааснаар шүүх хуралдаан дээр тайлбарлаж өгнө.

Эрүүгийн хэрэгт хохирогчоор оролцож буй этгээд иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон бол тэрээр энэ хуульд заасан хохирогчийн эрхийг давхар эдэлж, үүрэг хүлээнэ.

**3.2.1** .Хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1.-д зааснаар иргэний нэхэмжлэгчийн гаргаж өгсөн хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзаж болохгүйн зэрэгцээ мөн зүйлийн 43.4.-т зааснаар иргэний нэхэмжлэгч нь дээрх баримт сэлтийг гаргаж өгөх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй болно.

**3.2.2**.Хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4.-т заасан **"нэхэмжлэлээ дэмжих, татгалзах"** эрхээ иргэний нэхэмжлэгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед хэрэгжүүлэх боломжтой ба нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх, ихэсгэх, багасгах нь мөн энэ эрхэд хамаарна.

**3.2.3.** Иргэний нэхэмжлэгч хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3.-т заасан **"шүүх хуралдаанд оролцох"** эрхээ эдлэхгүйгээр, түүний оролцоогүйгээр эрүүгийн хэргийг хэлэлцэх тухай хүсэлт гаргасан, эсхүл энэ тухай хүсэлт гаргаагүй боловч шүүх хуралдааны товыг мэдсэн атлаа шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй аль ч тохиолдолд хуулийн 244 дүгээр зүйлийн 244.1.-д зааснаар шүүх хэргийг хэлэлцэх, энэ хэрэгт гарсан иргэний нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх эрхтэй. Дээрх тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.2.-т заасан зохицуулалт хамаарахгүй.

**3.2.4**. Хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.7.-д заасан **"...шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах"** иргэний нэхэмжлэгчийн эрх нь мөн зүйлийн 43.3.8.-д заасан **"шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбоотой хэсэгт давж заалдах гомдол гаргах"**-аас гадна хуулийн 113 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлүүлэх хэлбэрээр хэрэгжинэ.

Иргэний нэхэмжлэгч хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8., 342 дугаар зүйлийн 342.1.-д зааснаар хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй боловч хуулийн 113 дугаар зүйлийн 113.1.-д заасан үндэслэлээр хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй байна.

**4.** Иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзах талаар заасан хуулийн 118 дугаар зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

**4.1.** Энэ зүйлийн 118.1.-д **"энэ хуулийн 117 дугаар зүйлд заасан үндэслэл байхгүй бол"** гэдэгт гэмт хэрэг гараагүй буюу гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учраагүй, эсхүл хохирол учраагүй этгээд шаардлага гаргасан байхыг хамааруулан ойлгоно.

Мөн заалтын **"үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болно"** гэсний дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор тогтоол гаргаж, уг тогтоолд иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас болон иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос тус тус татгалзах, эсхүл иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзах шийдвэрийг гаргаж, ийнхүү шийдвэрлэх болсон хууль зүйн үндэслэл ба хэргийн байдал, учир шалтгааныг тодорхой заана.

Энэ заалтын **"гомдол гаргах журам"** гэдэгт хуулийн 106-114 дугаар зүйлд заасан зохицуулалтууд хамаарна.

**4.2**. Мөн зүйлийн 118.2.-т **"шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд ... нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй"** гэж зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан тогтоол гарсан боловч тухайн иргэн, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлэл, эсхүл нэхэмжлэгчээр тогтоолгох хүсэлтийн аль нэгийг гаргасан бол уг тогтоолд гомдол гаргаж байсан эсэхээс үл хамааран шүүх нэхэмжлэл, хүсэлтийг хянан үзэж, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хүсэлтийг хэрэгсэхгүй болгохдоо шүүх хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолыг бус харин энэ зүйлийн 118.1.-д заасан хууль зүйн үндэслэл болон хэргийн байдал, учир шалтгааныг тодорхой заана.

Нөгөө талаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гарсан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзах тухай тогтоолууд нь иргэний журмаар нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлахгүйгээс гадна Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6.-т заасан үндэслэлд хамаарахгүй тул шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болохгүй.

**5**. Эрүүгийн хэрэгт иргэний хариуцагчаар татах ажиллагааг заасан хуулийн 119 дүгээр зүйлийн болон иргэний хариуцагчийн эрх зүйн байдал, эрх, үүргийг тодорхойлсон зарим зүйлийн заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

**5.1. "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хариуцах этгээд"** гэж хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.-д зааснаар насанд хүрээгүй яллагдагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хуулийн дагуу хариуцвал зохих хуулийн этгээдийг хэлнэ.

Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн боловч Иргэний хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх зүйн бүрэн бус чадамжтай 14-18 хүртэлх насны яллагдагчийн бусдад учруулсан хохирлыг түүний хууль ёсны төлөөлөгч буюу эцэг, эх, харгалзан дэмжигч Иргэний хуулийн 503 дугаар зүйлийн 503.5., 503.6.-д заасан үндэслэл, журмын дагуу хариуцан арилгана.

Насанд хүрээгүй яллагдагч сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон тохиолдолд түүний үйлдлийн улмаас учирсан хохирлыг асран хамгаалагч нь Иргэний хуулийн 503 дугаар зүйлийн 503.3.-т зааснаар хариуцна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хариуцвал зохих этгээдэд Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасан ажил олгогч, хуулийн этгээдээс гадна мөн хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3., 499.4., 500 дугаар зүйлийн 500.1., 501 дүгээр зүйлийн 501.1., 502 дугаар зүйлийн 502.1., 512 дугаар зүйлийн 512.1.-д заасан иргэн, хуулийн этгээд хамаарна.

**5.2**. Эрүүгийн хэргийн иргэний хариуцагч хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.-т заасан эрх эдэлж, хуулийн 76 дугаар зүйлийн 76.2.-т заасан тусгай үүргээс гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийн нийтлэг үүргийг хүлээнэ.

Гэм буруугүй болохоо нотолсноор хариуцлагаас чөлөөлөгдөх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.2.-т заасан зохицуулалт зөвхөн хуульд заасан тохиолдолд эрүүгийн хэргийн иргэний хариуцагчид хамаарна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгасан иргэний хариуцагч өөрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээс иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй. Иргэний хариуцагч уг нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгт гаргахгүйн зэрэгцээ иргэний нэхэмжлэлийн эсрэг сөрөг нэхэмжлэл гаргах эрхгүй.

**5.3**. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яллагдагчаас өөр хүн хариуцахгүй тохиолдолд яллагдагчийг иргэний хариуцагчаар тусгайлан татах шаардлагагүй.

**6**. Хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэл, нөхцлийг тогтоосон журмын талаарх хуулийн 120 дугаар зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

**6.1.** Энэ зүйлийн 120.1.-д заасан **"хохирлын хэмжээ"** гэдэгт Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.1.-д зааснаар

